



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/93

Есенбулаг сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний газар эзэмших эрхийг захирамжилсан шийдвэрээр хүчингүй болгохдоо эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд мэдэгдэл хүргүүлж, сонсох ажиллагаа зохион байгуулаагүй, тайлбар, санал гаргах боломж олгоогүй, бодит нөхцөл байдлыг тогтоож Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй Тайшир сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/125 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Захирамжийг хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Буян-Хишиг)-д, Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Эрдэнэ-Очир)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

